




2019 оны 6 дугаар сарын 03-07

НЭГ. ТОХИОЛДОЛД СУУРИЛСАН ТАНДАЛТЫН МЭДЭЭ

Улсын хэмжээнд 2019 оны 6 дугаар сарын 07-ны өдрийн байдлаар ЗӨСҮТ-д зоонозын халдварын хүний өвчлөлийн сэжигтэй байж болзошгүй нийт 661 яаралтай дуудлагыг хүлээн авсан байна. Эдгээрийн 91(13.8%) галзуугийн эрсдэлд өртсөн, 555(84%) хачигт халдвар, 4(0.6%) боом, 3(0.4%) тарваган тахал, 2(0.3%) хумхаа, 1(0.1%) ям, 2(0.3%) денги, 3(0.4%) бэтэг өвчний сэжигтэй тохиолдол тус тус бүртгэгдсэн байна.

1.1. Галзуу өвчний эрсдэлд өртсөн тохиолдол:



Баянхонгор, Булган, Говь-Алтай, Дорноговь, Дундговь, Завхан, Орхон, Өвөрхангай, Өмнөговь, Сэлэнгэ, Төв, Увс, Ховд, Хөвсгөл, Хэнтий аймгийн 22 сум, нийслэлийн 4 дүүргээс галзуу өвчний эрсдэлд өртсөн нийт 91 тохиолдол мэдээлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 52%-иар, эпидемиологийн 22 дугаар долоо хоногтой харьцуулахад 2 тохиолдлоор тус тус нэмэгдсэн үзүүлэлттэй байна.



Галзуу өвчний сэжигтэй зэрлэг, мал амьтанд уруулж, ноцуулан, шүлсдүүлсэн хүмүүсийн тохиолдлыг эх уурхайгаар нь авч үзвэл: эзэнтэй нохойд (37.4%), чононд (20.6%), эзэнгүй нохойд (14.3%), үнэгэнд (8.8%), үхэрт (4.4%), мануулд (3.3%), мууранд (2.2%), тэмээнд (1.1%) нь уруулж, ноцуулж вакцин, ийлдэс эмчилгээнд хамрагдсан байна.

1.2 Хачгаар дамжих халдварт өвчний сэжигтэй тохиолдол:

Архангай, Баянхонгор, Булган, Баян-Өлгий, Дорнод, Дундговь, Дорноговь, Дархан-Уул, Говьсүмбэр, Говь-Алтай, Өмнөговь, Өвөрхангай, Ховд, Хэнтий, Хөвсгөл, Завхан, Сэлэнгэ, Төв, Увс, Орхон, Сүхбаатар аймгийн 116 сум, нийслэлийн 7 дүүрэгт хачгаар дамжих халдварын 555 сэжигтэй тохиолдол мэдээлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 27.3%-иар буурсан. Эпидемиологийн 22 дугаар долоо хоногтой харьцуулахад 1 тохиолдлоор нэмэгдсэн үзүүлэлттэй байна.



2019 оны 6 дугаар сарын 07-ны өдрийн байдлаар ХР-ын 469 сэжигтэй тохиолдлын 38(8.1%), ХБ-ын 47 сэжигтэй тохиолдлын 13 (27.6%), ХЭ-ын 39 сэжигтэй тохиолдол 4(10.2%) тархвар судлал, эмнэлзүй, лабораторийн шинжилгээгээр онош батлагдсан байна.

1.3 Мэрэгч амьтны дуудлага:

2019 оны 6 дугаар сарын 03-ны өдрийн байдлаар нийслэлийн 4 дүүргийн (БЗД, БГД, СХД, СБД) хэмжээнд нийт 18 удаагийн амьтны дуудлаганд үйлчилж, хураагдсан сорьц материалыг ЗӨСҮТ-ийн лабораторид шинжлэхэд тарваган тахал түүнтэй хам тохиолдох өвчин үүсгэгч илрээгүй байна.

Өнгөрсөн хоногт нийслэлийн СБД, БЗД-ээс ирүүлсэн мэрэгч амьтны (2 ширхэг тарвага) дуудлаганд үйлчилсэн. Сорьцод онош тодруулахаар лабораторийн шинжилгээ хийж байна

Монгол улсад:

Галзуу өвчний мал, амьтны өвчлөл:

Төв аймгийн Эрдэнэ сумын 1-р багийн “Баян давааны ар” гэдэг газар малчин “С”-ийн 1 үхэр 2019 оны 6-р сарын 03-ны өдөр галзуу өвчний шинж тэмдэгтэй хорогдсон тул сорьц авч УМЭАЦЛ-д шинжлүүлэхэд 6-р сарын 05-ны өдрийн хариугаар галзуу өвчин болох нь тогтоогдсон. Төв аймгийн ЗӨСТ галзуу өвчнөөс сэргийлэх сургалт зохион байгуулж, зөвлөгөө өгч ажилласан байна.


Эх сурвалж: Төв аймгийн ЗӨСТ

ХОЁР. ТУХАЙН 7 ХОНОГТ БҮРТГЭГДСЭН ЗООНОЗЫН ШАЛТГААНТ ҮЙЛ ЯВДЛЫН МЭДЭЭ


Олон улсад:

Эбола вируст халдвар:

2019 оны 6 дугаар сарын 03-ны өдрийн байдлаар Бүгд Найрамдах Ардчилсан Конго улсад Эбола вируст халдварын сэжигтэй тохиолдол 1945 тохиолдол бүртгэгдэж, үүнээс 1302 (67%) нь нас барсан. Нийт тохиолдлын 1122 (58%) нь эмэгтэйчүүд, 572 (29%) нь 18-аас доош насны хүүхдүүд эзэлж байна.



Хүснэгт 1. Эпидемиологийн долоо хоногоор



Зураг 1. Эбола вирус халдварын тархалт, БНАК улс

Эх сурвалж: ДЭМБ

Африкийн гахайн мялзан өвчин:

Эх сурвалж	Хаана	Мэдээлсэн хугацаа	Өртсөн хугацаа	Нэгж	Өртөмхий	Өвчилж үхсэн	Устгасан
ДМАЭМБ	• Вьетнам • Да Нанг тосгон	2019.05.31	2019.05.30	Аж ахуй			12 гахай
ДМАЭМБ	• Хонг Конг • New Territories	2019.06.05	2019.05.31	Нядалгааны газар			4158 гахай
ДМАЭМБ	• Румын • Илфов	2019.06.04	2019.05.27	Цэцэрлэгт хүрээлэн		1 гахай	
ДМАЭМБ	• Латив • Талсу	2019.06.04	2019.05.31	Ойд		1 зэрлэг гахай	
ДМАЭМБ	• Өмнөд Африк • Гуантинг	2019.06.04	2019.05.24	Аж ахуй	98 гахай	25 гахай	
ДМАЭМБ	• Белги • Люксембург	2019.06.03	2019.05.25	Ойд			1 зэрлэг гахай
ДМАЭМБ	• Польш • Подлаские	2019.06.03	2019.05.28	Аж ахуй	8012 гахай	61 гахай	7951 гахай
ДМАЭМБ	• Украин • Виннц	2019.06.03	2019.05.28	Аж ахуй	121 гахай	11 гахай	110 гахай

Эх сурвалж: ДМАЭМБ

Адууны ханиад:

Сенегал улсын Мал, амьтны эрүүл мэндийн газрын мэдээгээр 2019 оны 5 дугаар сарын 28-нд Тиес тосгоны аж ахуйд адууны ханиад бүртгэгдэж, 129516 адуу өртөмхий байснаас 3 адуу өвчилсөн тухай Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллагад мэдээлсэн байна.



Эх сурвалж: ДМАЭМБ

ЗӨСҮТ-ийн Шуурхай удирдлагын нэгж